

2. Төрийн "Big data (их өгөгдөл)" бий болгоход иргэн, хуулийн этгээдийг таних боломжгүйгээр нэгтгэх

ЗОРИЛГО

Их өгөгдлийн мэдээллийг цуглуулж, хязгаарлалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох шийдлийн дагуу Их өгөгдлийн "Big data" сан үүсгэж, төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах боломж бүхий систем хөгжүүлэх.

2.85
тэрбум
төгрөг

ХҮРЭХ ҮР, ДҮН

Их өгөгдлийн мэдээллийг цуглуулж, хязгаарлалттай мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох шийдлийн дагуу Их өгөгдлийн "Big data" сан үүсгэж, төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах боломж бүхий систем хөгжүүлсэн байна.

ҮНДЭСЛЭЛ

- ✓ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дугаар зорилтын 1 дүгээр үе шат, хүрэх үр дүнгийн 2 дахь заалтад "Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө." гэж, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.5 дахь заалтад "Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно." гэж тус тус заасан. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлийн хоёр дахь заалтад "Их өгөгдлийн (big data) сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох талаар Үндэсний статистикийн хороотой хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгасугай" гэж, мөн Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны нэгдүгээр тэмдэглэлд "Их өгөгдөлд суурилсан ур чадварт дүн шинжилгээ хийж, төрийн албаны хүний нөөцийн удирдлагын оновчтой загвар нэвтрүүлэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, дэмжин ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нарт" гэж, мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн "Их өгөгдлийн (big data) сан" үүсгэх тухай 403 дугаар тогтоолоор "Үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Их өгөгдлийн (big data) сан"-г үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээг Үндэсний статистикийн хороотой хамтран хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай" гэж заасан